



1989 оны 4 сарын 13 өдөр

БНМАУ

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ТОГТООЛ

дугаар 88

Улаанбаатар

хот

Нийслэлийн багш нарын "арга зүй, соёл мэдээллийн төв" байгуулж ажиллуулах тухай

Нийслэлийн багш, сурган хүмүүжүүлэгчид, хүүхдийн байгууллагын ажилтнуудын мэргэжил, боловсрол, хүүхэдтэй ажиллах арга зүй, соёл хүмүүжлийн түвшинг дээшлүүлэх, тэдний дунд зохиох улс төр, соёл хүмүүжлийн олон хэлбэрийн ажлыг нэгдсэн бодлоготой явуулах, чанар, үр дүнг сайжруулахад багш нарын арга зүй, соёл мэдээллийн нэгдсэн төв байх шаардлагатай байгааг үндэслэн Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Монголын багш нарын Ү их хурлын өмнө хотын ардын боловсролын удирдах газрын харьяанд "Нийслэлийн багш нарын арга зүй, соёл мэдээллийн төв" байгуулж ажиллуулсугай.

2. Хамран сургах тойргийн суралцах сурагчид цөөрч, хүчин чадлыг бүрэн ашиглаж чадахгүй байгаа болон бэлгийн XIII хороололд 1296 суудалтай шинэ сургууль ашиглалтанд орж байгаагаар холбогдуулан Сүхбаатарын районы 8 жилийн IY сургуулийг 1989 оны 6 дугаар сарын I-нээр тасалбар болгон татан буулгаж, Сүхбаатарын районы сургууль, цэцэрлэгийн нэгдсэн аж ахуйн балансаас хотын ардын боловсролын удирдах газрын балансад уг сургуулийн барилгыг шилжүүлж, "Нийслэлийн багш нарын арга зүй, соёл мэдээллийн төв" болгон ашиглуулсугай.

3. Уул барилгын гадна тал, анги танхимын хаалга цонх, зарим өрөө тасалгааны зориулалтыг өөрчлөн засвар хийх зураг төсвийг энэ оны 4 дүгээр сарын 25-ны дотор хийж, 6 дугаар сарын 10-ний дотор уг барилгад нийслэлийн ерөнхий боловсролын дунд сургуулиудын мужаан, хөдөлмөрийн багш нар, Барилгын ТМС-ийн багш, сурагчид зэрэг боломжтой бүх хүчийг төвлөрүүлэн зохион байгуулах замаар засвар хийлгэхийг Барилгын удирдах газар /н.Найдан/, Архитектур төлөвлөлтийн газар /н.Жадамбаа/, засварын хөрөнгийг

2.

нийт орлогын төлөвлөгөө давуулан биелүүлсэний шагналын хөрөнгөнөөс гаргахыг Санхүүгийн хэлтэс /н.Гонгор/-т тус тус даалгасугай.

4."Нийслэлийн багш нарын арга зүй, соёл мэдээллийн төв"-д тавих дотоод тоног төхөөрөмжийн хөрөнгийг мөн орлогын төлөвлөгөө давуулан биелүүлсэний шагналын хөрөнгөнөөс, үзүүлэн тавих, техник хэрэгслэлийн хөрөнгийг ардын боловсролын төсвөөс гаргаж санхүүжүүлэхийг Санхүүгийн хэлтэс /н.Гонгор/, Ардын боловсролын удирдах газар /н.Батмагнай/-т даалгасугай.

5.Уг барилгыг цаашид 600-700 хүний суудалтай соёл үзвэрийн заал, зоогийн газартай байхаар өргөтгөх зураг төсвийг 1990 оны 8 дугаар сарын I-ний өмнө хийлгэхийг Барилга захиалагчийн товчоо /н.Гомбосүрэн/, Ардын боловсролын удирдах газар /н.Батмагнай/-т даалгасугай.

6.Багш нарын "арга зүй, соёл мэдээллийн төв" байгуулахтай холбогдуулж доорх арга хэмжээг авч ажиллахыг хотын ардын боловсролын удирдах газар /н.Батмагнай/-т даалгасугай.Үүнд:

а/IV сургуульд Октябрь, Ажилчин, Найрамдлын районоос явж суралцаж байгаа сурагчдын тус тусын районы харьяалах тойргийн сургуульд, Төмрийн заводын ажилчин байр болон I төрөх газрын өмнөх айл өрхийн хүүхдийг Найрамдлын районы 2I дүгээр сургуульд, бусад сурагчдыг хамран сургах тойргийн дагуу Сүхбаатарын районы IO жилийн 2 дугаар сургуульд шилжүүлэн оургах;

б/Сүхбаатарын районы VII хороололд шинээр ашиглалтанд орох 928 суудалтай сургуульд "4" гэсэн дугаар өгч одоогийн сургуулийн орон тоо болон үндсэн хөрөнгийг шилжүүлэх;

в/тус төвийг засварлах, заал танхимыг тоноглох, үзүүлэн материалыг бэлтгэх ажилд багш нарын хүчийг төвлөрүүлэн зохион байгуулах, уг асуудлыг хэрэгжүүлэхэд Ардын боловсролын яамнаас бүх талын туслалцаа дэмжлэг авах;

г/арга зүй, соёл мэдээллийн төвийн тэмдэг, албан бичгийн нүүр хийлгэх.

7."Багш нарын арга зүй, соёл мэдээллийн төвд хотын сургалт заах аргын кабинетыг байрдуулж ажиллуулахын хамт төвийн захирал болон бусад шаардагдах орон тоог Төлөвлөгөө, эдийн засгийн улсын

3.

хороонд тавьж шийдвэрлүүлэхийг орлогч дарга Л. Жигжидсүрэнд, төсвийг баталж өгөхийг Санхүүгийн хэлтэс /н.Гонгор/-т даалгасугай.

8.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг орлогч дарга н.Жигжидсүрэнд даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТТЭХ
ЗАХИРГАНЫ ДАРГА

С. МӨНХЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д.АЛІНА

6.Сургууль, багш нарын ажлын тэргүүн туршлага, эцэг, эх хөдөлмөрчдөд зориулсан сурган хүмүүжүүлэх ухааны лекц, ярианы сэдэв, зөвлөмж, аргачлалыг боловсруулан хэвлэх, олшруулах.

7.Сургууль, үйлдвэр, албан газрын дэргэдэх эцэг эхийн зөвлөл, ОСГ-ны хорооны хүмүүжлийн төв, хүүхдийн секц болон бусад хүмүүжлийн байгууллагуудыг арга зүйн удирдлагаар хангах "Ардын их сургууль"-ийг хичээллүүлэх.

8.Сургууль, багш нарын дунд урлаг, уран сайхан, биеийн тамир спортын хамтлагууд байгуулах, уралдаан тэмцээн, спартакиад чуулга, явуулах ажлыг арга зүйн удирдлагаар хангах.

9.Эцэг эх, багш, хүмүүжүүлэгч, сурагчдын дунд эрүүл аж төрөх ёс, ахуйн соёлыг хэвшүүлэхэд арга зүйн зөвлөлгөө өгч, туслалцаа үзүүлэх.

10.Залуу техникчдийн салбар станц, соёл хүмүүжлийн төвүүдэд мэргэжлийн туслалцаа үзүүлэн хамтарсан төлөвлөгөөтэй ажиллах.

11.Сурагчдын дунд гүнзгийрүүлсэн ба сонгон, төрөлжсөн сургалтыг явуулах, гоц авъяастай хүүхдийг тодруулан хөгжүүлэх ажлыг их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага зэрэгтэй хамтран зохиох.

12.Сурагчдыг амьдрал хөдөлмөрт бэлтгэх, техник зохион бүтээх авъяас чадварыг хөгжүүлэх чиглэл бүхий төрөл бүрийн дугуйлан, бүтээлч групп, бригад байгуулан ажиллуулах явдлыг бүх талаар дэмжин туслалцаа үзүүлж байх.

13.ХЗЭ, пионер, сурагчдын байгууллагын өөрийгөө удирдах чадварыг хөгжүүлэх талаар лавлах, заах аргын захидал, зөвлөмж боловсруулан хүргэж байхын хамт районы болон сургуулийн дэргэдэх ХЗЭ, пионерын байгууллагын ажилд байнгын зөвлөлгөө өгч ажиллах.

14.Багш, сурган хүмүүжүүлэгчдийн дундаас судалгаа шинжилгээний ажил явуулах хүсэл сонирхолтой хүмүүсийг нэгтгэсэн зөвлөл байгуулж, тэдний ажилд туслалцаа үзүүлэх, зохиол бүтээлийг нь хэвлэн нийтлэх, сурталчлах ажлыг эрхлэх.

3.

15.Төвийн харьяанд түшиц сургууль, цэцэрлэг, заах аргын нэгдэл ажиллах ба тодорхой асуудлаар туршилт, судалгаа явуулж нэгтгэн дүгнэж байх зэрэг болно.

В/Төвийн ажиллах журам

1.Төв нь хотын ардын боловсролын удирдах газрын харьяанд ажиллах ба түүгээр дамжуулан улсын төсвөөр санхүүжинэ.

2.Төвийн орон тоо, төсөв төлөвлөгөөг зааврын дагуу батлуулан ажиллана.

3.Төвийн дэргэд 9-II хүний бүрэлдүүнтэй орон тооны бус арга зүйн зөвлөл ажиллана.

4.Төв нь сурган хүмүүжүүлэх ухааны хүрээлэн, багш нарын мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйн удирдлага, туслалцааг авч ажиллана.

5.Төвийн дэргэд багш нарын номын сан, арга зүйн лаборатори, "Эрдэм" хамтлаг, кино сан, тэргүүн туршлагын байнгын үзэсгэлэн, "Багш" хоршоолол, хөдөлмөр мэргэжлийн баримжаа олгох танхим болон бүтээлч клуб, хамтлагууд ажиллана.